

**ГОВЬСҮМБЭР АЙМАГТ ШИЛЖИН ИРЖ БАЙГАА ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ДЭМЖИХ
АЖЛЫН ХҮРЭЭНД СҮМБЭР СУМААС 2023-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 11 дугаар сарын 28 -ны өдөр

Сүмбэр

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Шаардагд ах хөрөнгийн хэмжээ /сая.₮/	Санху үжилт ийн эх ү үсвэр	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилт ийн хувь
Зорилго 1. Орон нутагт иргэд, ААН-ийг шилжин суурьшихад дэмжих замаар хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, татварын бааз суурийг нэмэгдүүлэх								
Зорилт 1.1. Аймаг, орон нутгийг сурталчлах, уулзалт, зөвлөгөөн, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэдээлэл хүргэх.								
1.1.1.	Орон нутагт шилжин ирэгсдэд олгож байгаа боломж, дэмжлэг нөхцлүүдийн жагсаалтыг гарган цахимд болон бусад хэлбэрээр /газар, өмчлөл, бизнес, татварын хөнгөлөлт гэх мэт/ нийтэд мэдээллэх	Нийтэд мэдээллэсэн тоо /давхардсан тоогоор/	-	20 удаа	-	-	Говьсүмбэр аймагт зарлагдсан сул орон тооны ажлын байрны зар болон Улсын бүртгэл болон Татварын Ерөнхий газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Сүмбэр сумын Засаг даргын тамгын газраас орон нутагт шилжин ирэгсдэд олгож байгаа боломж, дэмжлэг, иргэн аж ахуй нэгжид үзүүлэх хөнгөлөлтийг талаарх 18 төрлийн мэдээллийг иргэдэд цаг тухай бүрд нь хүргэж давхардсан тоогоор нийт 21596 гаруй хандалт хандалтыг авсан байна.	90
1.1.2.	Соёл, урлаг, зан заншлаа сурталчилсан эвент арга хэмжээ зохион байгуулах, сурталчлах	Зохион байгуулсан эвент арга хэмжээ Хамтран ажилласан байгууллага Хамрагдсан	-	1 18	20.0	ОНТ	Соёл урлаг, зан заншил боржигин өв соёлыг сурталчлах зорилгоор Соёлын сэргэлт 2023, Соёлын өвийн наадам 2023 /отог байгуулах/, зэрэг арга хэмжээнүүдэд “Боржигин морин хуур, Боржигин эмээлний үзэсгэлэнг дэглэж, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 1 цагийн	100

		<p>- дотоодын аялагчдын тоо</p> <p>гадаадын жуулчдын тоо</p>		<p>4000</p> <p>150</p>		<p>тоглолтыг 2 удаа зохион байгуулж 10 000 иргэнийг хамруулсан. Мөн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдаар дамжуулан соёлын биет бус өвийг уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, төрөөс соёлын талаар хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг иргэдэд мэдээлэх зорилгоор "Сүмбэр сумын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 2 дугаар зөвлөгөөн"-ийг Говьсүмбэр аймгийн Боржигин өв музей, Дуу бүжгийн Боржигин чуулгатай хамтран 150 өвлөн уламжлагчийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>Боржигин морин хуур, уртын дууны өв сангаас суралцуулах, урын санг баяжуулах, мартагдсан дууг сэргээх, өсөр залуу үеийнхэнд зааж сурталчлан таниулах зорилгоор 5 аймгийн 16 сумдуудын уртын дууч, морин хуурчдын дунд Монгол улсын гавъяат жүжигчин И.Цогбадрахын нэрэмжит "Боржигин морин хуур, Боржигин уртын дуучид"-н уралдааныг 64 өвлөн уламжлагч, боржигин уртын дууч, боржигин морин хуурчидыг оролцуулан зохион байгуулсан.</p> <p>Хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх монгол уламжлал буюу нүүдлийн соёл иргэншлийн өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хадгалан үлдээх зорилгоор "Аугаа монгол" төрийн бус байгууллагатай хамтран "Би монгол хүн" арга хэмжээнд 18 авьяаслаг сурагчийг хамруулсан.</p>
--	--	--	--	------------------------	--	---

1.1.3.	Зочлох үйлчилгээний салбарын байгууллагуудын чадавхийг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх	Нэмэгдсэн ажлын байрны тоо	-	10		ХХО	Зочлох үйлчилгээний салбарын ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт 11 ортой зочид буудлыг шинээр ашиглалтад оруулан 3 ажлын байр нэмэгдүүлсэн.	100
1.1.4.	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 21 аймгийн хэвлэл мэдээллийн багийн группт тавигдсан шинэ мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх	Хүргэсэн мэдээллийн тоо	-	10	-	-	Шинэ Сэргэлтийн бодлогын хүрээнд зохион байгуулагдаж буй ажлуудыг нэн даруй сурталчлах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүний дагуу нийт 18 мэдээллийг нийтлэж бусдын 22 мэдээг нийтэд хүргэж ажилласан нийт хандалтын тоо 10700 байна.	100
Зорилт 1.2. Орон нутагт бүртгэлтэй, үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагааг үргэлжлүүлэх, хүчин чадлаа нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.								
1.2.1.	Орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа нь зогссон 72 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих	Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	-	30	-	-	Сумын хэмжээнд үйл ажиллагаа нь зогссон 47 аж ахуйн нэгжийн судалгааг гаргасан ба 1 аж ахуйн нэгж хөнгөлөлттэй үнээр хадлангийн тоног төхөөрөмж авч Төв аймгийн Баянжаргалан суманд хадланд гарч 13 мянган боодол өвс авч орон нутгийн болон зэргэлдээ аймаг сумдын малчдад худалдан борлуулаад байна. Мөн аймгийн татварын хэлтэстэй хамтран 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор орон нутагт татвар төлөгчөөр бүртгүүлсэн.	80
1.2.2.	Үйл ажиллагаа нь зогссон аж ахуй нэгжүүдэд “Бизнесээ хэрхэн хөгжүүлэх вэ” сэдэвт сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, арга зүйгээр хангах, зээлийн бодлогоор дэмжих	Зохион байгуулсан сургалтын тоо Хамрагдсан ААН-ийн тоо Үйл ажиллагаа нь сэргэсэн ААН-ийн тоо	-	4 50	100.0 сая төгрөг	Хоршоо хөгжүүлэх сан	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Жижиг дунд үйлдвэрийн газар, Best сургалтын төвтэй хамтран 2023 онд Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хэрхэн хамрагдах тухай сургалтыг зохион байгуулж орон нутгийн жижиг дунд	

		Зээлд хамрагдсан ААН-ын тоо		5 1			үйлдвэрлэл эрхлэгч 29 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдсан. Мөн аймгийн ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдахаар 7 аж ахуйн нэгж 857,5 сая төгрөгний төсөл хүргүүлсэн бөгөөд нарийвчилсан судалгааны шатанд 647,9 сая төгрөгний санхүүжилттэй 5 төсөл шалгарч дараагийн шатны үнэлгээ хийгдэж 3 аж ахуй нэгж мал аж ахуй, агуулах, зоорийн чиглэлээр шалгаруулалтад тэнцэн нийт 398,0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.	100
1.2.3.	Орон нутгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хоршоо, олон төрөлт хоршоо, бусад иргэн, ААН-д Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг авсан хоршоо, ААН-ийн тоо ХХС-ийн зээлд хамрагдсан иргэний тоо Үүнээс гарааны бизнесийн төсөлд олгосон зээлийн хэмжээ Шилжиж ирсэн ААН-ийн тоо		5-аас доошгүй 1-ээс дээш 1-ээс дээш 1-ээс дээш	300.0 сая.төг-өөс доошгүй	ХХС	Аймгийн ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдахаар 7 аж ахуйн нэгж 857,5 сая төгрөгний төсөл хүргүүлсэн бөгөөд нарийвчилсан судалгааны шатанд 647,9 сая төгрөгний санхүүжилттэй 5 төсөл шалгарч дараагийн шатны үнэлгээ хийгдэж 3 аж ахуй нэгж мал аж ахуй, агуулах, зоорийн чиглэлээр шалгаруулалтад тэнцэн нийт 398,0 сая төгрөгний санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн ХХҮГ-аас зарлагдсан жижиг зээлд 3 иргэн хамрагдаж 60,0 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагааг явуулж байна.	100
Зорилт 1.4. Орон нутагт ажиллаж, амьдарч байгаа боловч шилжин ирээгүй иргэдийг шилжүүлэх, бүртгэх.								
1.4.1.	Улаанбаатар Төмөр Замын харьяа Чойр өртөө, Замын 3-р анги, ТҮГазар, Чойр солилцох тасаг, Галын анги болон замын баруун талд үйл ажиллагаа явуулж байгаа ААНэгжийн ажилчин албан	Бүртгүүлсэн иргэдийн тоо	-	120	-	-	Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Замын 3-р анги-372, Чойр өртөө-228, ТҮГазар-40, Чойр солилцох тасаг-49 ЦХАнги – 41, БОСууц-70, Сансар цэцэрлэг-18, Ган зам дэлгүүр -4, ТЗ-ын эмнэлэг -5, УВТранс ХХК-10, 108 Ойл-37, Хос Хүлэг -5, Сан	80

	хаагчдын судалгааг гаргаж, бүртгэж авах.						Степпа ХХК-200, Говь Урал ХХК-8, Мөнхсүмбэр ХХК-3 ажилчидтай. Үүнээс Говьсүмбэр аймгийн харьяалалтай 437 иргэн байна.	
1.4.2.	Цахим шилжилт хөдөлгөөний талаар сурталчилгаа нөлөөллийн ажил зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангах	цахим шилжилт хөдөлгөөн хийгддэг болсон байна. (Сурталчилгааны тоо Хандсан иргэдийн тоо)		30 1000	3.0	УТХ, ОНТ	Цахимаар шилжилт хийх болон иргэдийн шилжилт хөдөлгөөн хийх заавар зөвлөгөөг “Сүмбэрийн мэдээ” хуудсаар дамжуулан иргэдэд хүргэсэн бөгөөд нийт хандалтын тоо 10100 байна. Мөн багийн Засаг дарга нар дээр үйлчилгээ авч байгаа 531 иргэнд цахим шилжилт хөдөлгөөн хийгддэг болсон талаар мэдээлэл өгч ажилласан.	100
Зорилт 1.6. Сүмбэр суманд Чойр өртөөг өргөтгөж, авто болон төмөр замд тулгуурласан тээвэр логистикийн төв байгуулах ажлыг судалж, бодлогоор дэмжих								
1.6.1.	Чойр өртөөг өргөтгөх ачиж буулгах талбайг нэмэгдүүлэх ажлыг газрын бодлогоор дэмжинэ.	Гүйцэтгэлийн хувь	-	10	-	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчид	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Сүмбэр сумын 1 дүгээр баг замын баруун талд 1 га газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар сумын Засаг даргын 2023 оны 05 сарын 09-ны өдрийн А/109 тоот захирамжаар газар эзэмших эрхийг олгосон.	100
1.6.2.	Сүмбэр суманд худалдаа, үйлчилгээний төвүүдийг байгуулах, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн салбаруудыг байгуулахыг бодлогоор дэмжих.	Шинээр бий болсон зочид буудлын тоо		1	2000.0	ХХО	2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр “СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС” ХК-ны “Си Юү 353” салбар дэлгүүр шинээр үйл ажиллагаа эхлүүлээд байна. Ингэснээр 12 байнгын ажлын байрыг нэмэгдүүлсэн.	100
Зорилт 1.7. Орон нутаг болон бүс нутгийг хүнсээр хангах, хүнсний зориулалтаар стандартад нийцсэн агуулах зоорийг нэмэгдүүлэх, хүнсний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх.								

1.7.1.	Хүнсний зориулалтаар стандартад нийцсэн агуулах зоорийг нэмэгдүүлэх	Шинээр бий болсон зоорийн хэмжээ, тн		500-аас доошгүй	2.3 тэрбум төг	ХХО, УТХО	<p>Сумын хэмжээнд хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий 9 зоорь байдаг бөгөөд энэ онд хувийн хэвшлийн 2 аж ахуй нэгж гүн хөргүүртэй зоорийг шинээр ашиглалтад бүрэн оруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Аймгийн ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлэнд 1 аж ахуйн нэгж хамрагдан 98,0 сая төгрөгний санхүүжилт аваад байна. 11-р сарын байдлаар 1 иргэн 3 аж ахуйн нэгж зоорио ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэн 7,9 тн мах, 85 тн төмс хүнсний ногоо зоорилоод байна.</p> <p>Тэвшийн хажуу ус хоршоо нь Хөдөө аж ахуйн биржтэй түүхий эд борлуулан хамтран ажиллах гэрээ байгуулсан. Аймгийн ХХААГ, газартай хамтран 1 удаагийн хяналт шалгалт зохион байгуулсан.</p>	100
Зорилт 1.11. Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцах, мөн шилжин ирж ажиллах нарийн мэргэжлийн хүний нөөц, инженер, техникийн ажилтан, мэргэжилтнүүдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн болон орон байрны дэмжлэгийг үзүүлэх.								
1.11.1.	Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцах оюутнуудад гэрээ байгуулж, тэтгэлэг олгох	Дэмжлэг авсан оюутны тоо	10	15	30.0	ОНТ	<p>Орон нутагт нэн шаардлагатай, эрэлттэй мэргэжлээр суралцаж буй оюутнуудад “Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг” олгох үйл ажиллагааг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>2023-2024 оны хичээлийн жилд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хамрагдахаар материал ирүүлсэн оюутнуудаас болзол шаардлагыг бүрэн хангасан 20 оюутанг шалгаруулж, тус бүрд 2.0 сая төгрөг буюу нийт 40.0 сая төгрөгийн “БАТЛАМЖ”-ийг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр гардууллаа. Мөн тэтгэлэгт хамрагдсан оюутнууд төгссөний дараа орон нутагтаа эргэн ирж ажиллахаар гэрээ байгууллаа.</p>	100

1.11.2.	Шилжин ирсэн иргэдийг ажлын байр, нийгмийн баталгаагаар хангах арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Ажлын байраар хангагдсан иргэний тоо		4 600	3.0	ОНТ	Сумын хэмжээнд шилжин ирсэн 155 иргэний 45 иргэнийг түр ажлын байраар, 39 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.	100
1.11.3.	Орон нутагт байгаа сул ажлын байрыг нөхөх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Нөхөгдсөн сул орон тооны тоо		2 350	2.0	ОНТ	Сүмбэр суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудад нэн шаардлагаттай бага ангийн багш, математикийн багш, орос хэлний багш, химийн багш, их эмч, сувилагч малын зоо техникч зэрэг ажлын байрны судалгааг төрийн албаны салбар зөвлөл, боловсрол шинжлэх ухааны газарт хүргүүлсэн. Байгууллагын хэмжээнд төрийн захиргааны 6 албан тушаалын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж 4 сул орон тоо нөхөгдсөн. ТЖАХ-ийн ерөнхий болон тусгай шалгалтад түр томилгоотой 3 албан хаагч шалгалт өгч тэнцсэн.	100
1.11.4.	Сул ажлын байранд ажиллах иргэдийг мэргэшил олгох сургалтыг үе шаттай зохион байгуулах	Сургалтад хамрагдсан иргэний тоо		150		ХЭДС, ОНТ, УТХО	Хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэл сургалтад 114 иргэн хамрагдсан. Үүнд: -Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтыг “Хүний нөөцийн туслах ажилтан, цахим ур чадвар, харилцаа, сэтгэл зүй” сэдэвт сургалт 20 эмэгтэй хамрагдсан. -Хөдөлмөрт бэлтгэх “Суурь ур чадвар”-ын 3 удаагийн сургалтад 55 иргэн хамрагдсан. -“Аж ахуй эрхлэлтийн сургалт”-д хувиараа хөдөлмөр эрхэлдэг 39 иргэнийг хамруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний санхүүгийн дэмжлэг хүссэн төсөлд сумын 37 иргэний	100

							төсөл дэмжигдэж 250,0 сая төгрөгийн санхүүжилт олгогдож өмнөх оноос 2,6 хувиар өссөн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд сумын хэмжээнд байнгын ажлын байр 180, түр ажлын байр 186 бий болж өмнөх оноос байнгын ажлын байр 57, түр ажлын байр 18 нэмэгдсэн үзүүлэлттэй байна.		
Зорилго 2. Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах									
Зорилт 2.4. Бизнес эрхлэгчид болон гарааны бизнесийг зээлийн болон газрын бодлогоор дэмжих									
2.4.1.	Бизнес эрхлэгчдийг орчин үеийн техник технологийн дэвшил, инновацид тохируулж одоо байгаа уламжлалт бизнес, шинэ бизнесээ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүйн сургалтад хамруулах, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн бодлогоор дэмжих	<p>Зохион байгуулсан сургалтын тоо</p> <p>Хамрагдсан бизнес эрхлэгчдийн тоо</p> <p>Зээлд хамрагдсан иргэн, хоршоо, ААН-ын тоо</p> <p>Инноваци нэвтрүүлсэн бизнес эрхлэгчдийн тоо</p>	4	4	62	100	237,0 сая төгрөг	<p>Хоршоо хөгжүүлэх сан</p> <p>Гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор төсөл хөтөлбөрт хамрагдаж буй иргэдэд “Төсөл хэрхэн бичих”, “Төслийн санхүүжилтээ хэрхэн зарцуулах”, “Төсөлд тавих хяналт” гэсэн сэдвүүдээр 3 үе шаттайгаар сургалт зохион байгуулж нийт 24 иргэн Аймгийн ХХҮГазраас Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг 8 ахмад /хөдөө аж ахуйн чиглэлээр 4, гар урлал оёдолын чиглэлээр 3 удаагийн сургалтаар 1 иргэн/ нийт 38,0 сая төгрөг, санхүүгийн дэмжлэг олгох төсөлд, газар тариалангийн чиглэлээр 1 иргэн, ахуй үйлчилгээний чиглэлээр 4 иргэн, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр 4 иргэн, гар урлалаар 1 иргэн нийт 10 иргэн 97,0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд ахуй үйлчилгээ хөдөө аж ахуйн чиглэлээр 34,0 сая төгрөг нийт 24 иргэнд 169,0 төгрөгний дэмжлэг олгоод байна.</p> <p>Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан “Хоршоод мах боловсруулах үйлдвэрийн бизнес түншлэл” зөвлөгөөнд 4 хоршооны 6</p>	100

							<p>гишүүн хамрагдаж мах худалдан борлуулах талаар Дорнод аймгийн 2 хоршоотой хамтран ажиллах гэрээ байгуулсан.</p> <p>ХААХҮХолбооноос Дундговь аймагт зохион байгуулагдсан хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөнд 7 хоршооны 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. Мөн нийт 26 хоршооны гишүүд Дундговь аймгийн Гурвансайхан сумын “Давших зам” хоршоо, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Бат- Өлзий сумдын хоршоо болон ноос, арьс ширний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан. Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд Эко тансаг гашуун болон Тэвшийн хажуу ус хоршоодууд өөрсдийн үйлдвэрлэсэн цагаан идээ болон даршилсан хөмүүлээр оролцож Тэвшийн хажуу ус хоршоо нь Хөдөө аж ахуйн биржтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан.</p>	
<p>Зорилго 3. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, суурь дэд бүтцийг өргөтгөж, иргэдийн ажиллаж, амьдрах орчин, нөхцлийг сайжруулах, ажлын байраар хангах, хүний хөгжлийг дэмжих замаар нийгмийн харилцааг хөгжүүлэх зорилтын хүрээнд:</p>								
<p>Зорилт 3.1.Шилжин ирж байгаа иргэдийг орон сууцаар хангах зорилгоор хуучин орон сууцыг засварлах, шинээр барих ажлыг төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх.</p>								
3.1.1.	Сүмбэр суманд 40 айлын хаус хороололыг эхлүүлэх	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	30	-	ХХО	<p>Сүмбэр сумын 3-р багийн нутаг дэвсгэрт баригдах “Хаус хороолол төсөл”-ийг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлыг хэсэг томилогдож хаус хороолол төслийн ажлын даалгавар боловсруулсан. Төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах урилгыг 2023 оны 06 дугаар сарын 13-27-ны өдөр хүртэл,</p>	30

							08 сарын 01-31-ны өдрийг хүртэл хүлээн авахаар олон нийтийн сүлжээгээр мэдээллийг хүргэсэн боловч төсөлд материал ирүүлсэн оролцогч байгууллага байхгүй байна.	
Зорилт 3.4. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрсдлээс хамгаалах, эрчимжсэн аж ахуйг дэмжих.								
3.4.1.	Мал аж ахуйн үйлдвэрлэлээс мах бэлтгэл, махны нөөц бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх, экспортын эрхтэй ААН-тэй хамтран ажиллах.	Уламжлалт аргаар бэлтгэсэн мах /тн/ Махны нөөцийн хэмжээ /тн/ Экспортын эрхтэй ААН-тэй гэрээтэй иргэн, ААН		3000 100-аас дээш 25-аас дээш		ХХО ОНТ	Энэ оны 11 сарын байдлаар байдлаар 2 иргэн 4 аж ахуйн нэгж уламжлалт аргаар 368 тн мах бэлтгэн худалдаанд нийлүүлж, 24 тн мах нөөцлөөд байна. Мөн 2 аж ахуйн нэгж, 1 хоршоо Хөдөө аж ахуйн биржтэй хамтран ажиллах гэрээ байгуулан итгэмжлэгдсэн төлөөлөгч болсон.	100
3.4.2.	МАН-н үйлдвэрлэлийг эрсдлээс хамгаалах, нөөцийн бүрдүүлэлтийг хангах, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Аймаг, сумын аюулгүйн нөөцийн бүрдүүлэлт %/ Тэжээл тариалсан талбай /га/ Хураасан ургац /тн/		90-ээс дээш 60-өөс дээш 100-аас дээш		ХХО ОНТ	Сумын засаг даргын 2023 оны 08 сарын 11-ны өдрийн 2023-2024 оны Өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах тухай А/01 дугаар албан даалгаврын хүрээнд малчдын түвшинд 5200 тн өвс, 50 тн ногоон тэжээл, 945 тн үйлдвэрийн тэжээл, 91 тн гар тэжээл, 460тн давс, хужир, шүү бэлтгээд байна. Сумын аюулгүй нөөцөд 50 тн өвс 25 тн тэжээл авахаар тендер зарлан худалдан авсан. ОНХСангаас 16 050 000 төгрөг, 2021 оны өвсний орлогоос 27 000 000 төгрөгийг зарцуулсан. Сумын хэмжээнд 5,5 га талбайд ногоон тэжээл тариалж 85 тн ургац хураан авсан	100
3.4.3.	Эрчимжсэн мал аж ахуйн болон гахай, шувууны томоохон аж ахуйн хөгжлийг дэмжих, бүс байршлын мэдээллийг нийтэд сурталчлах,	Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуй Гахайн өрхийн аж ахуй		10-аас дээш 15-аас дээш		ХХО ОНТ	Сумын хэмжээнд 194 гахай, 160 тахиа, галуу 14, цацагт хяруул 1 нийт 369 тэжээвэр амьтан тоологдсон нь өмнөх оноос гахай	80

	зээлийн болон татварын бодлогоор дэмжих	Шувууны өрхийн аж ахуй 1000-аас дээш өндөглөгчтэй аж ахуй 200-аас дээш үндсэн мэгжтэй аж ахуй		20-оос дээш 1-ээс дээш 1-ээс дээш			41, тахиа 72 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Мөн 0,2 тн тахиа, 3,1 тн гахайн мах үйлдвэрлэсэн нь өмнөх оны энэ үеэс 0,17 тн махаар нэмэгдсэн байна.	
3.7. Иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах								
3.7.1.	Сумдын ундны усны эх үүсвэрийн нөөцийн нарийвчилсан судалгааг хийх, санхүүжилтийг шийдвэрлүүлэх.	Санхүүжилт шийдвэрлүүлэх саналаа холбогдох газарт хүргүүлсэн байх Нөөцийн судалгаа хийгдсэн байдал	Шинэ ажил	Шаардл агатай төсвийг шийдвэрлүүлсэн байх		УТХО	Сумын Усан сан, ус түгээх байрууд нь “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-т ус олборлон түгээх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага болох Ус –Ду ОНӨААТҮГ-н харьяалалд шилжсэн бөгөөд ус түгээх байруудыг төвлөрсөн системд бүрэн холбосон 12 ус түгээх газруудын хамгаалалтын зурвас болон тэрэгтийн ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуй хамгаалалтын бүсийг сэргээн засаж 120 мод тарьж ойжуулах арга хэмжээг авсан. Умард говийн гүвээт халхын Дундад талын сав газартай хамтран нэгдсэн удирдамж гарган сумын 1, 2, 3, 4-р багийн нутагт буй худгийн судалгааг сүүлийн 3 жилээр гарган, 4-р баг Тэрэгтийн ундны усны эх үүсвэр, 3-р баг Баянбулагийн ус түгээх байрнуудын эрүүл ахуйн бүсэд байрлаж байгаа 19 айл өрхүүдэд яаралтай доторлогоотой бие засах газартай болгох талаар шаардлага хүргүүлсэн. Энэхүү ажлын үр дүнд 9 айл өрх доторлогоотой бие засах газартай болсон үзүүлэлттэй байна.	100
3.7.2.	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Ногоон байгууламж /талбай/	14 га	15 га	140.0 сая	ОНТ	Сүмбэр сумын хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэд олон нийтийг мод тарихад уриалах чиглэлээр хавар, намар “Мод тарих өдөр” арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд	100

							ногоон байгууламжийг 11,3 га талбайгаар нэмэгдүүлж шинээр 22471 мод тарьсан. Намрын тооллогоор шинээр тарьсан модны ургалт 80 хувьтай байна. Мод тарих ажиллагаанд нийт 37 байгууллагын 650 албан хаагч, 588 өрх хамрагдсан. Шинээр тарьсан мод өмнөх онтой харьцуулахад 13,6 хувиар, ногоон байгууламжийн хэмжээ 4,6 га-р нэмэгдсэн байна. 2023 онд ШШГ-425-р анги 35,000 модны суулгацыг бэлтгэн орон нутагт борлуулсан.	
3.7.3.	Шахмал түлшний үйлдвэр байгуулах иргэн, ААН-ийг үе шаттайгаар дэмжих	Газрын асуудлыг шийдвэрлэх Татварын хөнгөлөлт үзүүлсэн байна	Шинэ ажил	2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан байх		ХХО	Хугацаа болоогүй	-
3.7.4.	Хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлыг ангилан ялгах, дахивар авах цэг байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулах	Байгуулагдсан дахивар авах цэгийн тоо Ажлын байрны тоо Дахиварт нийлүүлсэн хог хаягдлын хэмжээ Дэмжлэг үзүүлсэн байдал	2 2 11 тн	3 12 Гүйцэтгэл /зээл болон бусад/		ОНТ	Сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 2.3 дах хэсэгт заасны дагуу 2023-2024 оны хооронд нөлөөллийн ажлуудыг голчлон зохион байгуулахаар төлөвлөсний үндсэн дээр "Хоггүй Сүмбэр" пэйж хуудсыг ажиллуулж эхэлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн 32 байгууллагууд 14 хоног тутамд нийтийн эзэмшлийн хуваарьт талбайн цэвэрлэгээг зохион байгуулж, хийсэн ажлаа цахимаар нийтэд тайлагнаж ажиллаж байна. "Хүн бүр байгаль хамгаалагч" аянд нэгдэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 28 байгууллага, 150 гаруй иргэдийг хамруулан 2 цэцэрлэгт хүрээлэнг	100

						цэвэрлэж 36 тн хог хаягдал, бүх нийтийн их цэвэрлэгээг 4 удаа зохион байгуулан 68 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн. Сумын 1, 2, 3-р багийн нийтийн эзэмшлийн талбайд 24 ширхэг хуванцар хог хаягдал хаядаг хогийн сав байршуулах ажлыг сумын ОНХС-ын “Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ”-ний зардлаас 6,0 сая төгрөгийг зарцуулан “Жавхлант аривжих” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж төвийн 3 багийн нийтийн эзэмшлийн 11 цэгт байршуулж ажилласан.	
3.7.5.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төвийн ногоон байгууламжийн арчилгааны ажлыг үе шаттайгаар хувийн хэвшил, иргэн ААН-аар гүйцэтгүүлэх, модны үрсэлгээ, суулгац бэлтгэж буй иргэдийг худалдан авалтаар дэмжих замаар байнгын болон улирлын чанартай ажлын байруудыг бий болгож, улирлын чанартай хөдөлмөр эрхлэлтийн төсөлд иргэдийг хамруулах	Байнгын ажлын байрны тоо Түр ажлын байрны тоо	5 100	Байнгын ажлын байр 15 Улирлын чанартай ажлын байр 120	УТХО ОНХО	Төвийн нийтийн эзэмшлийн тохижилт, ногоон байгууламжийн арчилгааг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт “Хоггүй сүмбэр-Ногоон хот” төсөл бичиж нийт ажилгүй 45 иргэний түр ажлын байраар ханган ажиллаж байна. Төслийн нийт хөрөнгө оруулалт 16,200,0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож байгаа болно. Эхний хагас жилийн байдлаар 30 иргэнийг түр ажлын байр сумын ногоон байгууламжийн талбайд ажиллуулсан. Төвийн 3 багт үйл ажиллагаа 6 байгууллага өөрийн эзэмшлийн талбайд 8400 модыг тарьж, усалгаа, арчилгааг хариуцан хийж, өөрийн эзэмшил газарт мод тарих боломжгүй үйлдвэрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг 5 компани нийтийн эзэмшлийн 2 цэцэрлэгт хүрээлэнд 8 нэр төрлийн 900 мод, бутыг тарьсан. Нийтийн эзэмшлийн 2 цэцэрлэгт хүрээлэнгийн 1600 модны усалгаа, арчилгаа,	100

						<p>хамгаалалтыг “Нарт боржигины тал” ХХК-тай гэрээ байгуулан ажилласны үр дүнд 2 талбайн ногоон байгууламжийн ургалт 6 сарын хугацаанд 75 хувийн ургалттай, хашаа хайсны эвдэрсэн гэмтсэн засвар үйлчилгээ хамгаалалтын ажил 100 хувь, цэцэрлэгт хүрээлэнгүүдийн талбайн хог хаягдал, мод, бутны тогоон дахь элс, шороо цэвэрлэх зэргээр байнгын усалгаа, арчилгааг хариуцах сахиул ажиллах зэрэг нь ногоон байгууламжийн ургалт, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, өнгө үзэмж сайжирах, иргэдэд ая тухтай байлгах гэх мэтчилэн үр дүнтэй шинэлэг ажил болсон.</p>	
Нийт үнэлгээ							94,4

ТАЙЛАН ХЯНАСАН:
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.НАРАНМАНДАХ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.САРНАЙ